



ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД

**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.08.07, № 229

танай _____-ны № _____-г

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Орхон аймгийн Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 – 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 – 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн



2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Орхон аймгийн Монгол Ардын намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Намын мөрийн хөтөлбөр⁶ хуудсыг хавсаргав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

**“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР “2024-2028” он**

УРИА: “НИЙГМИЙН АРДЧИЛАЛ-ХҮНИЙ ХӨГЖИЛ”

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1. Эрүүл мэнд
- 1.2. Боловсрол
- 1.3. Соёл, Спорт
- 1.4. Нийгмийн хамгаалал, нийгмийн баталгаа
- 1.5. Хөдөлмөр эрхлэлт

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 2.1. Төсвийн бодлого
- 2.2. Түлш, эрчим хүч

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

- 3.1. Цахим засаглалын хөгжил
- 3.2. Төрийн үйлчилгээний чанар хүртээмж
- 3.3. Нутгийн удирдлагын байгууллагын чадавх
- 3.4. Төрийн албаны хүний нөөцийн чадавх, нийгмийн баталгаа
- 3.5. Хууль, эрх зүйн бодлого, хэрэгжилт, иргэдийн аюулгүй байдал

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: НОГООН ЭРДЭНЭТ-ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

- 4.1. Цаг уурын өөрчлөлт, сорилтыг даван туулах бодлого
- 4.2. “Ус”-ны бодлого, хэрэгжилт
- 4.3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх бодлого, үйл ажиллагаа
- 4.4. Сумын доторх ногоон хөгжил

ТАВДУГААР БҮЛЭГ: ХӨДӨӨ АЖ АХУЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

- 5.1. Шинэ хоршоо хөдөлгөөн
- 5.2. Мал аж ахуй
- 5.3. Газар тариалан

ОРХОН АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМ

**“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР (2024-2028 он)**

УРИА: “НИЙГМИЙН АРДЧИЛАЛ-ХҮНИЙ ХӨГЖИЛ”

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

1.1.ЭРҮҮЛ МЭНД

1.1.1.Сумын хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог хэвшүүлж, иргэдийн дундаж наслалтын хүйсийн ялгаатай байдлыг багасгах бодлого хэрэгжүүлнэ.

1.1.2.“Цахим эрүүл мэнд” хөтөлбөр хэрэгжүүлж, хяналтын тогтолцоог сайжруулан, иргэдэд учирч болзошгүй санхүүгийн болон эрүүл мэндийн эрсдэлээс сэргийлнэ.

1.1.3.“Эрүүл Жаргалантчууд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, эрүүл мэндийн салбарын ажилтны мэдлэг, ур чадвар дадлыг хөгжүүлэн харилцаа хандлагыг сайжруулж, нийгмийн баталгааг хангах тусгай бодлого хэрэгжүүлнэ.

1.1.4.Сумын эрүүл мэндийн төвийн барилга, байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан, дэвшилтэд технологи нэвтрүүлэх, стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.

1.1.5.Яаралтай тусламжийн болон хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний иж бүрдлийг шинэчлэн, үйлчилгээг сайжруулна.

1.2.БОЛОВСРОЛ

1.2.1.Боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэйгээр зохион байгуулж, хүүхдийг дарамт хүчирхийллээс ангид байх таатай орчныг бүрдүүлэн, иргэдийг насан туршийн боловсролд хамруулан, тасралтгүй суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.

1.2.2.“Оюунлаг Жаргалант” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил төлөвшлийг хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлстэй шүтэлцүүлэн, орон нутагт нийцсэн хөтөлбөрөөр сургалт явуулна.

1.2.3.Шинээр 180 хүүхдийн цэцэрлэгийн зураг төсвийг боловсруулж, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.

1.2.4.Өвлийн спортыг хөгжүүлэх иж бүрэн талбай, хэрэглэгдэхүүнээр хангаж, сурагчдын авьяас чадварыг хөгжүүлнэ.

1.2.5.Эрүүл чийрэг хүүхэд бий болгох зорилгоор 330 сумаас анхдагч болж сумандаа хүүхдийн болон иргэдэд зориулсан усан бассейнтай болж, суралцагч нэг бүрийг амжилттай суралцахад чиглүүлнэ.

1.2.6.Ерөнхий боловсролын сургуулийн их засварыг үе шаттайгаар хийж дуусгах, байгалийн ухааны кабинетыг бий болгох, тоног төхөөрөмж эд хогшлоор хангаж стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол олгох орчныг бүрдүүлнэ.

1.3.СОЁЛ, СПОРТ

1.3.1.“Соёлыг дэмжих” хөтөлбөрийг шинээр боловсруулан хэрэгжүүлж, орон нутаг иргэдэд хүргэх соёлын хүртээмжийг нэмэгдүүлж, хүний нөөцийг чадавхжуулна.

1.3.2.Төр-иргэний хамтын ажиллагааны түншлэлд үндэслэж, соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтнох чадварыг хамгаалан, сумын нутаг дэвсгэрт түүх, соёлын үл хөдлөх дурсгал, соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэн сумын соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. .

1.3.3.Мэргэжлийн урлагийн байгууллага болон соёлын төвийн менежментийг сайжруулж, материаллаг бааз, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

1.3.4.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож сумын наадмын талбайг шинээр барьж стандартад нийцсэн 4 улирлын стадионыг барьж төвлөрсөн байр, талбай бий болгон үндэсний өв, соёлд түшиглэн орчин цагийн бүтээл хөгжүүлэх үйл ажиллагааг нь дэмжинэ.

1.4.НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, НИЙГМИЙН БАТАЛГАА

1.4.1.Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахимд шилжүүлэн нээлттэй болгож, хүүхэд, залуучууд, гэр бүл, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, зорилтот болон нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.4.2.Анхан болон лавлагаа шатлалын оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлж, дэвшилтэд технологи нэвтрүүлснээр иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

1.4.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлж, тэдэнд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.

1.4.4.Ахмад настны хөгжлийн хөтөлбөрийн боловсруулан хэрэгжүүлэх

1.4.5.Ахмад залуучуудын ордны үйл ажиллагааг тогтмолжуулж шаардлагатай хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийг шийдвэрлэж үйл ажиллагааг дэмжинэ.

1.4.6.“Халамжаас хөдөлмөрт” бодлогыг хэрэгжүүлэн зорилтот бүлгийн иргэдийг тогтвортой ажилд зөвлөн чиглүүлж, ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрт хамруулан дэмжинэ.

1.4.7.Баялагийн сан, нийгмийн даатгалын сангаар дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлээр иргэдийг орон сууцжуулан түрээслэх болон түрээслээд өмчлөх орон сууцны төслийг үргэлжлүүлж хэрэгжүүлнэ.

1.5.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

1.5.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээс өрхийн үйлдвэрлэл, бичил бизнесийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлж, цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон, иргэдэд нэмэлт орлого олох боломж олгоно.

1.5.2.Асрахуйн эдийн засгийн хөгжлийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн эко системийг бүрдүүлж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдээ асарч буй болон зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

1.5.3.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.5.4.Өрхийн үйлдвэрлэлийг дэмжин, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг бий болгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1.ТӨСВИЙН БОДЛОГО

2.1.1.Улсын төсөвт төвлөрүүлж буй хөрөнгөнөөс сумын болон хойд бүсийн хөгжлийн стратегийг хангах шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг санхүүжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

2.1.2.Бүс орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдмэл цогц байдал, харилцан уялдааг хангана.

2.2.ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧ

2.4.1.Сумын цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлж, шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг шийдвэрлэн дэвшилтэт технологид суурилсан дэд бүтэц бий болгоно.

2.4.2.Ахуйн хэрэглээний түлээ, нүүрсний хэрэглээний менежментийг сайжруулна.

2.4.3.Сумын инженерийн шугам сүлжээнд ухаалаг систем нэвтрүүлж, найдвартай байдал, хангамж, хүртээмж, засвар, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, хүний нөөцийг хангах нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ.

2.4.4.Жаргалант, Улаантолгой багуудын гэр хорооллыг инженерийн шугам, сүлжээнд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.4.5.Сумын орон сууц болон төрийн байгууллагуудыг хэрэглээний халуун усанд холбох ажлыг үргэлжлүүлэн дуусгаж амьдрах таатай орчин нөхцөл бүрдүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

3.1.ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖИЛ

3.1.1.Төрийн цахим үйлчилгээний хэвийн ажиллагааг хангана.

3.1.2.Иргэдэд үзүүлж буй гол үйлчилгээнүүдэд процессын шинжилгээ хийж цахимжуулах, автоматжуулах замаар иргэд төрөөс авах үйлчилгээг хялбаршуулна

3.2.НУТГИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ

3.2.1.Нутгийн удирдлагын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн ялгааг оновчтой тодорхойлж ажиллана.

3.2.2.Нутгийн удирдлагын байгууллагын ил тод байдал, хамтын ажиллагаа, зохион байгуулалт, хариуцлагын тогтолцоог сайжруулна.

3.3.ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХ, НИЙГМИЙН БАТАЛГАА

3.3.1.Төрийн албаны хүний нөөцийн чадавх, хариуцлагын тогтолцоог сайжруулна.

3.3.2.“Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.3.3.Төрийн албан хаагчдын “Орон сууц” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.4.ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ, ИРГЭДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

3.4.1.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн орчинг төрийн бүх байгууллагад төлөвшүүлнэ.

3.4.2. Аюулгүй байдлын эрсдэлийн менежментийн чадавхыг бэхжүүлж, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг сумын хэмжээнд иж бүрэн үе шаттайгаар нэвтрүүлж, иргэдийн аюулгүй орчинг бүрдүүлнэ.

3.4.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

3.4.4. Зайлшгүй шаардлагатай асуудлаар “Нээлттэй сонгол”-ыг зохион байгуулж иргэдийн мэдэх эрхийг хангана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НОГООН ЖАРГАЛАНТ-ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

4.1. ЦАГ УУРЫН ӨӨРЧЛӨЛТ, СОРИЛТЫГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

4.1.1. Ногоон Жаргалант хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.1.2. Газрын хэвлийн зохистой ашиглалтыг сайжруулж, хөрсний бохирдлыг бууруулж сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.

4.1.3. Эрчим хүчний байгальд ээлтэй, хэмнэлттэй хэрэглээ, үр ашигтай дэвшилтэт ногоон технологийг дэмжинэ.

4.2. “УС”-НЫ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ

4.2.1. Усны хууль тогтоомжийн хэрэгжилтийг чангатгаж, суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж, усны нөөц бохирдож, хомсдохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.2.2. Гадаргын ус, газрын тогтоц, голын гольдирлын хэв шинжийг ашиглан хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулна.

4.2.3. Сумын цэвэрлэх байгууламжийг шинэчлэн өргөтгөнө.

4.3. “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ӨРНҮҮЛЭХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.3.1. Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

4.3.2. Ойг нөхөн сэргээх, ойн төгөл, ойн зурвас байгуулахад байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, мод үржүүлгийн газруудыг дэмжиж, шинээр байгуулах замаар тарьц, суулгацын хэрэгцээг хангаж, 20.0 сая ширхэг мод тарьж, ойн сангийн талбайг нэмэгдүүлнэ.

4.3.3. Мод, бут, сөөг тарьсан ногоон байгууламж нэмэгдүүлсэн, шинээр байгуулсан иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулна.

4.4. СУМЫН ТӨВ ДОТОРХ НОГООН ХӨГЖИЛ

4.4.1. Ногоон байгууламжийн хайс, хашлагыг эдийн засгийн өртөг багатай, технологийн шинэлэг хэлбэрийг ашиглан өөрчилж, хамгаалалтын хашааг мод, бут, сөөгний тарилтын үйл ажиллагаатай уялдуулан хийнэ.

4.4.2. Сумын ногоон байгууламжийн арчилгаа хамгаалалтыг сайжруулахад зориулагдсан техник технологийг шинэчилнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ХӨДӨӨ АЖ АХУЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

5.1. ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН

5.1.1. Шинэ хоршоо хөдөлгөөний үйл ажиллагааг эрчимжүүлж мал аж ахуйн чиглэлээр суурин, хагас суурин фермерийн аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэдийг дэмжинэ.

5.2. МАЛ АЖ АХУЙ

5.2.1. Малжуулах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх


5.2.2. “Малын эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, эрчимжсэн мал аж ахуй болон мал эмнэлгийн лабораторийн чадавхыг сайжруулж, малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг бодлогоор дэмжинэ.

5.3. ГАЗАР ТАРИАЛАН

5.3.1. Зах зээлд өндөр үнэ цэн бүхий бүтээгдэхүүнийг нийлүүлэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.

5.3.2. Жаргалантын ногоочид хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, бие даасан агро үйлчилгээний төв байгуулна.

5.3.3. Сумын аюулгүйн нөөцийн өвс тэжээлийг дотооддоо бэлтгэх ажлыг зохион байгуулна.



**ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМ**